

2023 он 04 сар 29 өдөр

Дугаар 23/01

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хүүлийн 62 дугаар зүйл 62.1.9 дэх хэсэг, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



П. БАТБАЯР

2023 он 04 сар 29 өдөр

Дугаар 23/02

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.7 дахь хэсэг, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр

Чулуун овогтой Ганхуяг

Авир овогтой Сүхдорж

Бруно овогтой Рашле

Одончимэд овогтой Одбаяр

2. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

Арно Вентура

Мөнх-Очир овогтой Сэргэлэн

Михаил Зелдович

Чулуун овогтой Мөнхбат

Пүрэвжаргал овогтой Батбаяр

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П. БАТБАЯР

2023 он 04 сар 29 өдөр

Дугаар 23/03

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.13 дахь хэсэг, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг "хавсралт 1"-ийн дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх болон Цалин, Урамшууллын хороонд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П. БАТБАЯР



Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2023 оны 4 сарын  
29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлын 43/25 тогтоолын хавсралт 1

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсөв**

(сая төгрөг)	Төсөв 2022	Гүйцэтгэл	Хувь	<b>Төсөв 2023</b>
ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	424	393.4	93	<b>424</b>
Томилолт	10	7.6	76	<b>10</b>
<b>НИЙТ</b>	<b>434</b>			<b>434</b>



2023 он 04 сар 29 өдөр

Дугаар 23/04

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

### Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.12 дахь хэсэг, компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.10, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК нь нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нөлөөллийг бууруулах, шинээр стратегийн хөрөнгө оруулагч татах зорилгоор өөрийн гаргасан хувьцааг "хавсралт 1"-ийн дагуу 2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор компанийн нийт гаргасан хувьцааны 10 (арав) хувийг эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.8 заалтын дагуу эргүүлэн худалдан авах үнэ нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын болон бусад арилжааны албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханш байна.

ХУРЛЫН ДАРГА



П. БАТБАЯР

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2023 оны 4 сарын  
29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлын 23 дугаар тогтоолын хавсралт 1

### ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

БҮРДЭЛ	ЗААЛТ	Компанийн тухай хууль
Зорилго	<i>Нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нөлөөллийг бууруулах; Стратегийн хөрөнгө оруулагч татах.</i>	49.4
Хугацаа	<i>2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор</i>	49.4
Хувьцаа халааслах ханш	<i>Сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг</i>	55.8
Төлбөр тооцоо хийх нөхцөл	<i>Гэрээ байгуулах</i>	49.5
Хувьцааны тоо ширхэг	<i>Нийт гаргасан хувьцааны 10 (арав) хувийг доорх компаниудаас эргүүлэн худалдан авахаар тохиролцсон; Ардын Тэтгэврийн Данс ХХК Ард Бит ХХК Ард Лизинг ХХК Ард Секюритиз ҮЦК ХХК</i>	49.5

